



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар A - 73

Улаанбаатар хот

Үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А-146 тоот тушаалаар батлагдсан “Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн 1.3 дахь хэсэгт “Токен үйлчилгээний систем (TYC)-д төлбөрийн карт шинээр бүртгүүлэх, дахин сунгах шимтгэл”-ийг хавсралтад заасны дагуу нэмсүгэй.

2. Батлагдсан тушаалыг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар, төлбөрийн системийн оролцогч наарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анаар), Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛЫГ
Б.ЛХАГВАСҮРЭН



1523010748

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2023 оны 04 дугээр сарын 07-ны өдрийн
А-33 дугаар тушаалын хавсралт

**МОНГОЛБАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС,
ШИМТГЭЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

| | Үйлчилгээ | Шимтгэл | Төлөх хугацаа |
|-----|---|--------------|------------------------|
| 1.3 | <i>Төлбөрийн картын гүйлгээ</i> Токен үйлчилгээний систем (ТҮС)-д төлбөрийн карт шинээр бүртгүүлэх, дахин сунгах | Токен тутамд | ₮1,000.0 Улирал бүр |